

МОНГОЛ ХЭЛНИЙ ОРНЫ УТГАТ ТИЙН ЯЛГАЛЫГ ЗАДЛАГ ХАМ БҮТЦЭЭР ИЛРҮҮЛЭХ НЬ

Ч.Бямбаханд

Товч хураангуй: Хэлний хэв шинжийн хувьд залгамал хэлний бүлэгт багтах монгол хэлний жинхэнэ нэр нь тийн ялгалаар бүрэн хувилдаг бол харин нэрийн хувиллаар дутмаг хувилдаг орон цагийн нэр нь тухайн эх, өгүүлбэрт хэлзүйжсэн холбоо үгийг бүтээх ба үүнийг задлаг арга гэнэ. Ийнхүү орон цагийн нэр нь туслах үгийн үүргээр орохдоо дан ганц нэрийн тийн ялгалын нөхцөлтэй утга дүйцэхүйц тохиолдож болно. Үүнийг нэгдүгээрт, жинхэнэ нэрийн орны утгат тийн ялгалын нөхцөлтэй нийлэг аргаар бүтсэн үйлийн холбоо үг; хоёрдугаарт, орон цагийн нэр нь тухайн эх, өгүүлбэрт туслах үгийн үүргээр орсон хэлзүйжсэн холбоо үг бүтээх задлаг арга; гуравдугаарт, жинхэнэ нэрийн орон цагийн утгат тийн ялгалын нөхцөлтэй нийлэг аргыг орон цагийн нэр бүхий задлаг аргатай харьцуулан гаргах; Ийнхүү жинхэнэ нэрийн орон цагийн утга илтгэх тийн ялгалын нөхцөлтэй нийлэг аргыг орон цагийн нэр бүхий задлаг аргатай харьцуулан эдгээрийн утгын төстэй ба ялгаатай талыг сонин нийтлэлийн найруулгын төрлийн жишээгээр задлан шинжилж, нэгтгэн дүгнэж гаргахыг оролдлоо. Улмаар орчин цагийн монгол хэлний үг нөхцөлийн утгын харилцан нөлөөллийг хэрэглээний жишээгээр тодруулан судлах нь хэл найруулгын онцлог хийгээд монгол хэл сурах-сургахад ач холбогдолтой юм.

Түлхүүр үг: *тийн ялгал, орон цагийн утгат тийн ялгал, орон цагийн нэр*

XX зууны хэл шинжээчид хэлийг бүтэц болон үүсгүүр хэл шинжлэлийн үүднээс хэлний тогтолцоог (langue, competence) судлахдаа хэлний хэрэглээнээс (parole, performance) ангид үзэж байсан бол улмаар танин мэдэхүйн ойлголтыг хэлээр илрүүлэхэд нэг нь нөгөөдөө багтсан хэлний дотоод бүтцийг зөвхөн хэлбэр бус агуулгын харилцан хамааралд нь авч үзэх болжээ. Иймд, орчин цагийн монгол хэлэнд үйлийн өнгөрсөнд болсон, одоо болж байгаа, ирээдүйд болох орон цагийн харьцаа заахад юм үзэгдлийг зааж байвал бие даасан утгатай, харьцаа заавал залгавар бүтээвэртэй холбогддог орон цагийн нэр¹ нь хэлбэрийн талаас бүрэн бус хувилдаг тул орон цагийн нэр нь үйлийн холбоо үг (VP), өгүүлбэр (SOV)-ийн доторх орон

¹ Монгол хэлний хувилах ба үл хувилах үгсийн хоёрдмол шинжийг хадгалсан орон цагийн нэрийн талаар И.Я.Шмидт (1831), А.Бобровников (1835), О.Ковалевский (1835), В.Л.Котвич (1902), А.Д.Руднев (1905), Н.Поппе (1937), (1951), (1954), Л.Хамбис (1945), Б.Х.Тодаева (1951), Г.Д.Санжеев (1960), Ш.Лувсанвандан (1956), (1961), М.Н.Орловская (1961), Жон Стрийт (1963), Чингэлтэй (1963), Т.А.Бертагаев (1964), (1969), Б.Ринчен (1967), Орчин цагийн монгол хэлний зүй (1966), Г.Ц.Пюрбеев (1993), Д.Төмөртоогоо (1992), Ц.Өнөрбаян (2004), М.Базаррагчаа (2005) нар монгол хэлний зүйд, Г.Д.Санжеев (1953), Н.Поппе (1955) нар монгол хэлний харьцуулсан хэл зүйд; А.Орлов (1878), Н.Поппе (1938), (1960), Г.Д.Санжеев (1941) нар буриад-монгол хэлний харьцуулсан хэл зүйд; Д.Д.Амоголонов (1958), Буриад хэлний хэл зүй (Г.Д.Санжеев, 1962), Т.А.Бертагаев, Ц.Б.Цыдендамбаев (1962), Д.Д.Доржиев (2002), Ц.Ц.Цыдыпов (1972), (1985), (1988) нар буриад хэлний зүйд; А.Бобровников (1849) монгол-халимаг хэлний харьцуулсан хэл зүйд; А.Попов (1879), В.Л.Котвич (1929), Г.Д.Санжеев (1940) нар халимаг хэлний зүй зэрэг бүтээлүүдээс гадна Ш.Лувсанвандан (1955), (1968), Ф.Х.Бак (1955) Л.Мишиг (1957a), (1957b), Ш.Барайшир (1958a) (1958b), (1966), (1974), Чойжинжав (1987) нар тусгайлан судалж, улмаар С.Л.Чареков (1989) алтайн хэлний бүлэгт багтах монгол хэлнүүдийн хүрээнд, харин Д.А.Алексеев (1962a) буриад хэлний дайвар үг, дагавар үгийг авч үзсэн бол харин С.М.Трофимова (1989), Н.Энхтуяа (1993) нар орос хэлтэй харьцуулж, улмаар Л.А.Лиджеиева (2004) халимаг хэлний талаас тусгайлан судалжээ.

цагийн утгыг нийлэг ба задлаг хам бүтцээр илрүүлэх утгын харьцааг жинхэнэ нэрийн тийн ялгалыг судалсан зарим эрдэмтдийн саналтай уялдуулан дурдлаа.

Академич Ш.Лувсанвандан жинхэнэ нэр, бодит нэр нь нөхцөлөөр хувилахдаа ‘-н’-тэй ‘-н’- гүй хоёр янз байгаад үндэслэн, харьяалах, өгөх орших, гарахын тийн ялгалд ‘-н’-тэй үндэс нэрлэх, заах, үйлдэх, хамтрахын тийн ялгалд “-н-гүй үндэс байдаг гэж ялгаад, эхнийх нь ‘ерөнхийдөө гол үгээр илэрсэн хүн юмын бэлгэ чанар, үйл байдлын болсон буюу үүссэн орон цаг, шалтгаан зэрэг шууд бус хийсвэр утгыг зааж, сүүлчийнх нь ерөнхийдөө үйл байдлын эзэн буюу тусагдахуун зэвсэг хэрэглүүр зэрэг зохих үзэгдэл юмыг шууд заасан бодит утгыг заана (Лувсанвандан, 1965) гэсэн бол орчин цагийн монгол хэлний тийн ялгалын утга, тэдгээрийн харьцаанд тулгуурлан нэрлэх ба заах, харьяалах ба хамтрахын тийн ялгалыг орон цагийн бус утгат, өгөх орших, үйлдэх ба гарах, чиглэхийн тийн ялгалыг орон цагийн утгат (Базаррагчаа, 1987) (1991) гэж ангилсан байна. Харин Цэцэнцогт тийн ялгалыг үндсэн (нэрлэх, харьяалах, өгөх орших, заах, гарах, үйлдэх), үндсэн бус (чиглэх, хэрлэх, байрших, цаглах, тодотгох) (Цэцэнцогт, 1988) хэмээн хуваажээ. Мөн түүнчлэн хэл шинжлэлд үндсэн тийн ялгалыг нэрлэн тэмдэглэж байгаа юмтайгаа хэрхэн харьцах шинжээр нь шууд ба шууд бус гэж ангилсан бөгөөд шууд тийн ялгалд нэрлэх, заахын тийн ялгалыг, шууд бусад нь үлдсэн тийн ялгалыг багтаажээ. Учир нь нэрлэх, заахын тийн ялгалд байгаа жинхэнэ нэр нь холбогдож байгаа үгэндээ харьцангуй хараат биш бие даасан шинжтэй байдаг онцлогтой (Өнөрбаян, 2004) гэсэн тул сонин нийтлэлийн найруулгын төрлийн жишээнээс монгол хэлний орны утгат тийн ялгалыг задлаг хам бүтэц (analytical structure)-ээр илрүүлэхэд орон цагийн нэр чухал үүрэгтэй тул монгол хэлний орны утгат тийн ялгалыг хэлзүйжсэн холбоо үгээр илрүүлэх боломжийг практик найруулга зүйн талаас хэрхэн хэрэглэж байгааг дурдвал:

Монгол хэлний орон цагийн нэр нь туслах үгийн үүргээр орохдоо дан ганц жинхэнэ нэрийн тийн ялгалын нөхцөлтэй утга адил байж болно. Жишээ нь: Энэ хугацаанд өөрийгөө нээхээс *гадна* аливаа зүйлийг түргэн сурах чадварт суралцаж байна. (www.dailynews.mn) гэхэд “*гадна*” гэсэн орон цагийн нэр нь өмнөх цагт нэрийг гарахын тийн ялгалаар захирсан боловч утгын хувьд “нээхэд” гэж болно. Гагцхүү уг хэлэх гэсэн санааг улам тодорхой болгохын үүднээс “гадна” гэдэг үгийг нэмэн найруулсан бөгөөд энэ үгийн оронд “зэрэгцээ, эхлэн, авхуулаад, урьд” гэх мэт үгсийг ч солин найруулах боломжтой юм.

Мөн дараах жишээ өгүүлбэрт “Хөдөө гадаа, бүх аймаг орон нутгаар аялна гэсэн нь ч юу болж дууссан юм *их айхтар халуун шатахаас* өмнө тэмээгээ буцаасан гэсэн хэмээн ойр тойрны нь оршин суугчид өгүүлж байна лээ. (www.dailynews.mn); “Өөртэй чинь *уулзахаас* өмнө ахынхаа “Аз жаргалын элч ирж явна” шүлгэнд аялгуу зохиосноо ардын жүжигчин Мөнхшүрт өгөөд ирлээ. (www.dailynews.mn); Тэр бээр энэ тухай онцлохдоо “Би АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгууль *болохоос* өмнө энэ тухай их бодсон л доо.” (www.dailynews.mn) гэхэд “өмнө” гэсэн орон цагийн нэр нь өмнөх цагт нэрийг гарахын тийн ялгалаар захирсан боловч утгын хувьд *шатахаар, уулзахад, болохоор* гэж цаг заасан утгыг илрүүлдэг боловч энэ судалгаанд зөвхөн орон байр, зүг чиг заасан утгаар судалгааны хүрээгээ тогтоосон болно. Энэ нь уг хэлэх гэсэн санааг илүү тодорхой болгохын тулд *өмнө* гэдэг үгийг нэмэн найруулсан бөгөөд энэ үгийн оронд *эхлэн, авхуулаад, урьд* гэх мэт үгсийг ч солин найруулж цагийн утга илтгэх боломжтой юм.

Хэлэхийн цуваа бүтцэд орон цагийн нэр нь өмнөх үгээ харьяалах, гарахын тийн ялгалаар захирдаг ч нэр үгийн хойно тохиолдвол өмнөх үгээ дагалдан, хэл зүйжсэн холбоо үгийн үүргээр тохиолдоно. Үүнийг хэл шинжлэлд дагавар үг (postposition) буюу туслах үг (function word), хэл зүйн үг (grammatical word) гэх мэтээр нэрлэсэн нь орон цагийн нэрийн үнэмлэхүй утгыг гаргахтай нягт уялдсан шалтгаан нь хэл зүйн найруулгын үүрэгтэй байж болно.

Задлаг хам бүтцээр илрэх туслах үг нь монгол хэлэнд өгүүлбэр, холбоо үгэнд бие даасан гишүүн болохгүй зөвхөн үндсэн үгийн хэл зүйн утгыг илтгэж ихэвчлэн бүтээврийн үүргээр тохиолдоно. Харин туслах үг болон бүтээвэр хоёр нь үүргийн хувьд бүрэн тохирохгүй (Серебренников, 1965) гэсэн бол аливаа хэлний задлаг хам бүтэц, холбоо үгийн адил хоёр

буюу хэд хэдэн үгээр бүтэх боловч тэдгээрийн нэг хэсэг нь үгийн сангийн хувьд биеэ даасан утгаа алдаж, хэл зүйн хувьд туслах чанартай үг болж хэрэглэгддэг (Рагчаа, 1975) тул орны утгат тийн ялгалыг задлаг аргаар хэлзүйжсэн холбоо үгээр хэрхэн илрүүлж болохыг авч үзье.

Тухайлбал, өгөх оршихын тийн ялгал нь харьяалахын тийн ялгалтай адил тул эртнээс бүрэлдэн тогтсон бөгөөд өгөх ба оршихоос гадна бас заах, үйлдэх зэрэг нэлээд олон тийн ялгал (нэрлэх, харьяалахаас бусад) -ын утгыг илтгэж байсан. Мөн заахын тийн ялгал ч өгөх оршихын утгыг илтгэж байв. Энэ нь тухайн тийн ялгалын хоорондох харьцаа холбоог харуулж байна. Монгол төрлийн хэлэнд өгөх оршихын тийн ялгал бас заах буюу үйлдэхийн тийн ялгалаар утга илтгэдэг (Цэцэнцогт, 1988) гэжээ.

Орчин цагийн монгол хэлэнд өгөх оршихын тийн ялгал нь олон салаа утгатай байхын зэрэгцээ үйлийн “хаана” орших орон, байрыг заасан утгаар үйлийн холбоо үг, өгүүлбэрт нийлэг аргаар илрэхээс гадна орон цагийн нэрийн тусламжтай задлаг аргаар утга илтгэдэг. Тухайлбал,

A.1.N_{dat-loc.}

- “Морины сэтэр” хэмээх судрыг уншиж эхлэхэд Монгол Улсын Ерөнхийлөгч Бурхан Халдун ууланд онголон сэтэрлэх хөх буурал морийг тэнгэрийн хүлэг болгох ёс үйлдэв (www.dailynews.mn) хэмээх өгүүлбэрт “ууланд онголон сэтэрлэх” (S-OBL-V_{trans.}) гэсэн үйлийн холбоо үгийг “уулнаа онголон сэтэрлэх”, “Фүжи ууланд нийт 10 зогсоол байх бөгөөд 5 дугаар зогсоол хүртэл машинтай явж болно (https://jargaldefacto.com) гэхийг “Фүжи уулнаа 10 зогсоол байдаг ч 5 дах зогсоол хүртэл машинтай явж болно.” (S-OBL-V) хэмээн найруулж болохоос гадна “Фүжи уулан дээр 10 зогсоол байдаг ч 5 дах зогсоол хүртэл машинтай явж болно” гэж үйлийн “хаана” орших орныг заасан өгөх оршихын тийн ялгалаар хэлбэржсэн “ууланд” гэсэн нийлэг хэлбэрээр илэрсэн үгийг “уулны дээр байдаг, уулан дээр байдаг”, “биржид бүртгэлтэй”, “бирж дээр бүртгэлтэй” хэмээн задлаг аргаар илрүүлж болно.

- Булган сумаас 30 гаруй километрт орших Байтаг богд ууланд 100-135 см цастай байгаа.” “Богд ууланд гарсан гүймрийг унтраахад хүмүүс сайн дураар оролцжээ.” (www.dailynews.mn) гэхэд “ууланд байгаа”, “ууланд гарсан” гэх үйлийн холбоо үгийг “уулнаа байгаа”, “уулнаа гарсан” хэмээн найруулж болохоос гадна “уулан дээр цастай байгаа”, “уулан дээр гарсан” хэмээн задлаг аргаар илрүүлж, улмаар “Нүдэнд гадны биет орсон үед нухвал эвэрлэг болон салст бүрхүүлийг гэмтээх, нүдний хараанд нөлөөлөх аюултай тул заавал ус болон нулимсаар гадагшлуулах хэрэгтэй.” (www.24news.mn) гэхэд “нүдэнд орсон” гэдгийг “нүдэн дотор орсон” хэмээн (S-OBL-V) орших орон заасан утгыг задлаг аргаар илрүүлбэл орон цагийн нэр туслах үгийн үүргээр орж утга зүйн талаас (S-theme-V) үйлийн эзэн-үйлд өртөгч-үйл үг гэсэн дарааллаар орж утгын хувьд харилцан холбоотой болж өгүүлбэр зүйн талаас (S-OBL-V_{intrans.}) гэсэн бүтэцтэй өгүүлбэрт орон цагийн нэр нь “хаана” гэх асуултад хариулагдаж орон заасан үйл үгэнд захирагдсан (VP) үйлийн холбоо үг болно.

Үүнээс гадна холбоо үг, өгүүлбэрийн бүтэц дэх өгөх оршихын тийн ялгалын нөхцөлийг бусад тийн ялгалаар солин найруулахаас гадна задлаг аргаар илрүүлэх нь хэлний зүй тогтлыг өргөн хүрээнд танин мэдэх боломжийг нэмэгдүүлнэ.

2. N_{dat-loc.}~N_{abl.}

“... энд эс гэхэд өөр ууланд халтирвал ер нь яаж аврах юм бол.” (www.dailynews.mn); Ер нь Швейцарьчууд, хүүхэд хөгшидгүй цана, чаргаар ууланд гулгах, уул хадаар явган аялахдаа гаргуун.(www.dailynews.mn); Сөл ихт нутгийн ус тунгалаг Угалзын голд ундаалсан адууны айраг авьяас бэлэгтэй охид, хөвгүүд төрүүлдэг гэж Сайханыхан хөөрөлддөг юм. (www.dailynews.mn) зэрэг өгүүлбэрт “ууланд халтир-”, “ууланд гулгах-”, “голд ундаал-” гэсэн тийн ялгалын нийлэг аргаар илэрсэн үйлийн холбоо үгийг “уулнаас халтир-”, “уулнаас гулга-”, “голоос ундаал-” гэж өгөх оршихын тийн ялгалын нөхцөлтэй нийлэг бүтцээр илэрсэн хэлбэржилтийг гарахын тийн ялгалаар солин найруулж, “уулан дээрээс халтир-”, “уулан дээрээс гулга-”, “гол дотроос ундаал-” хэмээн задлаг аргаар илрүүлнэ.

3. $N_{\text{dat-loc.}} \sim N_{\text{instr.}}$

- Хамгийн хурдан морьдоо наадамд унах гэж хүүхдүүдийн дунд сонгон шалгаруулалт болдог. (www.dailynews.mn); Барууны хөгжилтэй орнуудын өндөр зэрэглэлийн ресторануудын цэсэнд хонь, үхрийн чөмөгний ясны шөл, чөмөгний тосонд шарсан элдэв зүйлийн тансаг хоолнууд байдаг. (www.dailynews.mn); Үүнээс илүү дэлхийд гайхагдах үйл хэрэг манай нэн шинэ түүхэнд үгүй юм биш үү. (www.dailynews.mn) гэх өгүүлбэрт “наадамд уна-”, “тосонд шар-”, “дэлхийд гайхагд-” гэсэн нийлэг аргаар илэрсэн үйлийн холбоо үгийг “наадмаар уна-”, “тосоор шар-”, “дэлхийгээр гайхагд-” хэмээн өгөх оршихын тийн ялгалыг үйлдэхийн тийн ялгалаар солин найруулахын зэрэгцээ “наадам дээр уна-”, “тосон дотор шар-”, “дэлхий дээр гайхагд-” хэмээн задлаг аргаар ярианы хэлэнд ашиглаж байна.

4. $N_{\text{dat-loc.}} \sim N_{\text{adit.}}$

- Ноднин хоёр хүүтэйгээ Цамбагарав ууланд гарсан юм. (www.dailynews.mn); Фүжи ууланд авирах зам жил бүрийн 7 сарын 1-нээс 8 сарын 27-ны хооронд нээгдэнэ. (https://mn.wikipedia.org/wiki/Фүжи_уул), зэрэг өгүүлбэрт “ууланд” гэсэн өгөх оршихын тийн ялгалаар илэрсэн нийлэг хэлбэрийг (S-Obj-V) “уул руу”, “уул өөд” хэмээн хөдөлгөөн заасан үйл үгэнд захирагдсан зүг чиглэл заасан утгыг задлаг аргаар солин найруулж, “Алга ташихаа ч мартчихлаа, таны дуулахыг сонсоод жингүйдэх шиг боллоо, сансар огторгуйд оччихсон юм шиг л санагдлаа гэж ирээд л их сонин зүйл ярьдаг.” (www.dailynews.mn) гэхэд “огторгуйд” гэсэн тийн ялгалын нийлэг аргыг “огторгуй руу оч-”, “огторгуй өөд оч-”, “Сүүлд Өндөрхаан хотод ирээд ...” гэхийг “Сүүлд Өндөрхаан хот руу ирээд...” хэмээн зүг чиглэл заасан утгыг хөдөлгөөн заасан үйл үгэнд захирагдсан үйлийн холбоо үгийг задлаг аргаар хэлбэржүүлнэ.

Гарахын тийн ялгал нь тийн ялгалын тогтолцоонд өгөх оршихын тийн ялгалын дараа үүссэн. Учир нь эртний монгол хэлний үед өгөх оршихын тийн ялгал нь гарахын тийн ялгалын утгыг зохих хэмжээгээр илтгэж байсан бөгөөд хожим бий болсон гарахын тийн ялгал нь ерөнхийдөө өгөх оршихын тийн ялгалын хойно залгадаг байжээ. Монгол төрөл хэлэнд гарахын тийн ялгал нь утгын талаар гарахаас гадна өгөх орших, заах, үйлдэх утгыг илтгэдэг (Цэцэнцогт, 1988, 2879) бол орчин цагийн монгол хэлэнд гарахын тийн ялгал нь олон салаа утгатай байхын зэрэгцээ үйлийн хаанаас үүсэх үйл, хаанаас үүсэх орон заасан утгыг өгүүлбэрт нийлэг аргаар илрэхээс гадна орон цагийн нэрийн задлаг бүтцээр ч тохиолдоно.

Б.1. $N_{\text{abl.}}$

- Цагаан суварганы оройгоос цагаан оройн зай дэлгэгдэж, тэндээс цагаан шувууд ирж буудаг ч юм шиг мэдрэмжийн галыг асаамуу. (www.dailynews.mn); Жар орчим бээрийн энэ аялалдаа, замдаа таарсан нэг ч айлаар ороогүй юм даа тэгэхэд... (www.dailynews.mn) Фүжи уулнаас илгээсэн захидал (<https://jargaldefacto.com>); Туулын уснаас дээж авч шинжлэхэд Биокомбинат, Алтанбулагт урсч байгаа гол хамгийн их бохирдолтой байжээ. (www.dailynews.mn); Химийн иж бүрэн цэвэрлэгээ хийснээр бохир уснаас хromыг ялгаж авна. (www.dailynews.mn); Харин био дизелийг ургамлын тосноос гаргаж авсан юм. (www.dailynews.mn); ...газар дээр нь очиж зам гарцыг нээж 80 гаруй автомашин, 140 орчим хүнийг цаснаас эсэн мэнд гаргасан байна. (www.dailynews.mn) гэхэд “суварганы оройгоос дэлгэгдэж”, “уулнаас илгээ-”, “уснаас ав-”, “уснаас ялга-”, “тосноос гарга-”, “цаснаас гарга-” гэх нийлэг аргаар илэрсэн жишээг “суварганы орой дээрээс дэлгэгд-”, “уулан дээрээс илгээ-”, “усан дотроос ав-”, “усан дотроос ялга-”, “тосон дотроос гарга-”, “цасан дотроос гарга-” гэх зэргээр хөдөлгөөн заасан үйл үгэнд захирагдсан үйлийн холбоо үгийг задлаг аргаар таних боломжтой.

2. $N_{\text{abl.}} \sim N_{\text{dat-loc.}}$

- Хаа сайгүй харанхуй тэнгэрээс салют цацран нийслэл даяараа шинэ жилээ нижгэр тэмдэглэсэн билээ. (www.dailynews.mn) гэхэд “тэнгэрээс цацран” гэсэн үүсэх орон, үүсэх үйл “хаанаас юу цацрах” гэсэн утгыг илрүүлсэн гарахын тийн ялгалыг “харанхуй тэнгэрт цацарсан” өгөх оршихын тийн ялгалаар, “Энэ дуу бол зөвхөн хувь хүний сэтгэлээс урган

гарсан бүтээл” (www.dailynews.mn) гэхэд сэтгэлээс урган гарсан-сэтгэл дотроос урган гарсан, сэтгэлээс үүсэх - сэтгэлд үүсэх- сэтгэл дотор үүсэх” хэмээн найруулж болно.

-Зул сарын баярт зориулсан модыг Японы Осака хотын “Гинза Танаки” хэмээх үнэт эдлэлийн дэлгүүрээс харж болох гэнэ” (www.dailynews.mn) гэхэд “дэлгүүрээс харж болох” гэдгийг “дэлгүүрт харж болох” хэмээн гарахын тийн ялгалын нөхцөлийг тухайн юмын хаана оршин байгаа утгыг илтгэх өгөх оршихын тийн ялгалын нөхцөлөөр солин найруулж болохын зэрэгцээ “үнэт эдлэлийн дэлгүүр дотор харж болно” хэмээн задлаг аргаар ч илрүүлнэ.

-Гурван жилийн дараа Завханы Цагаан чулуут сумын Зүүн арц, Баруун арц гэдэг уулнаас фосфоритын хүдрийн биет илрэлүүдийг анх удаа олсон юм. (www.dailynews.mn) гэхэд “уулнаас олдсон” гарахын тийн ялгалын нөхцөлийг “ууланд олдсон” хэмээн өгөх оршихын тийн ялгалын нөхцөлөөр солин найруулахаас гадна “уулан дээрээс” хэмээн задлаг аргаар илрүүлдэг.

3. $N_{abl.} \sim N_{accu.}$

-... тухайн улс орны хувь заяаг ямар эмзэг байдалд оруулдгийг “Таван Толгой” тойрсон жишээнээс харж болно. (www.dailynews.mn) “жишээнээс харж болно” гэхэд гарахын тийн ялгалаар хэлбэржсэн хэсгийг “жишээг харж болно”, “асуудлаас харж болно.”, “асуудлыг харж болно” гэж заахын тийн ялгалаар солин найруулж болно.

Үйлдэхийн тийн ялгалыг эрдэмтэд эртний монгол хэлэнд үйлдэх, холбохын тийн ялгал байгаад хожим салбарласан гэж үздэг. (Цэцэнцогт, 1988, 2883) Харин орчин цагийн монгол хэлэнд “хаагуур?” гэсэн асуултад хариулагдах тул үйлийн холбоо үгэнд тухайн үйл болж байгаа зүг чиг, орон байрыг зааж хэлзүйжсэн байна.

В. 1. $N_{instr.}$

- Амлалтууд амьдралын хөрсөн дээр буухгүй тэнгэрээр л нисээд байна. (www.dailynews.mn); Усны шувууд халуун орноос ирэхдээ Номхон далай, Газар дундын тэнгисээр дайран урт удаан зам туулдаг. (www.dailynews.mn); Улс орны байдлыг шүүмжилсэн нийтлэл гадаадын сонин хэвлэлүүдээр гарах болсон. (www.dailynews.mn) зэрэг өгүүлбэрт “тэнгэрээр нисээд” гэхийг “тэнгэр дээгүүр нисээд”, “Газрын дундад тэнгисээр дайр-” гэхийг “Газрын дундад тэнгис дээгүүр дайр-”, “хэвлэлүүдээр гарах болсон” гэх үйлийн холбоо үгийг “хэвлэлүүдэд гарах” гэж адилхан нийлэг аргаар, “хэвлэлүүд дээр гарах” хэмээн задлаг аргаар найруулж болно.

2. $N_{instr.} \sim N_{nomi.}$

- Өнөө жилийн хувьд оюунлаг, авьяаслаг, бүтээлч, чадварлаг, ёс бэлэгт гэсэн таван номинациар нийт 40 гаруй гэр бүл нийслэлийн шилдэг айл гэрээр тодорсон юм. (www.dailynews.mn); Концерт эхлээд л хүмүүс “UB” паласын танхимаар дүүрчээ. (www.dailynews.mn); Бат гуай залуусын хэлдгээр шоудах, найр наадамд дуртай бол Жамсран гуай залуудаа ганц гэрээр буухыг илүүд үздэг байсан гэнэ шүү. (www.dailynews.mn) зэрэг өгүүлбэрт “шилдэг айл гэрээр тодорсон”, “танхимаар дүүрчээ”, “ганц гэрээр буух” гэсэн үйлдэхийн тийн ялгалаар хэлбэржсэн орон заасан нэр үгийг “шилдэг айл гэр тодорсон”, “танхим дүүрчээ”, “ганц гэр буух” гэж нэрлэхийн тийн ялгалаар солин найруулж хэлэхэд утгын ялгаа гарахгүй байна.

3. $N_{instr.} \sim N_{dat.-loc.}$

- Нийслэл хотоор бөөрөн дээрээ “Вайрелас ажиллаж байна” гэж бичсэн автобус хөлхөлдөх боллоо. (www.dailynews.mn); Өдгөө Улаанбаатар хотын захын сургуулиар ороод үзэхэд нэг ангид 45-58 хүүхэдтэй хичээллэж байх вий. (www.dailynews.mn); Ач нарынхаа гэрээр тэр бүр ороод байхыг боддоггүй. (www.dailynews.mn) гэхэд “хотоор хөлхөлдөх”, “сургуулиар ороод үзэхэд”, “гэрээр орох” хэмээн үйлдэхийн тийн ялгалаар хэлбэржсэн гишүүнийг “хотод хөлхөлдөх”, “сургуульд орох”, “гэрт орох” гэх мэтээр өгөх оршихын тийн ялгалаар хэлбэржүүлж солин найруулж болно.

4. $N_{instr.} \sim N_{accu.}$

- Зам нэлээд шувтарч, зорьсон газар болох Ширээтийн даваагаар давах үед нэг аялагчийн шөрмөс татсан. (www.dailynews.mn); Чингээд Загастайн даваагаар давж Улиастай хотод буучхав. (www.dailynews.mn); Хөвсгөлд явж байхдаа Дархадын 13 овоотой даваагаар нэг ч машин давж чадахгүй байхад ... бүх машиныг жолоодон гаргаж өгч байсан гэдэг. (www.dailynews.mn) зэрэг өгүүлбэр дэх “даваагаар давах” гэсэн үйлийн болох орон зааж байгаа үйлдэхийн тийн ялгалыг заахын тийн ялгалаар солин найруулж болохын зэрэгцээ “даваа дээгүүр давах” хэмээн задлаг аргаар илэрч болно.

5. $N_{instr.} \sim N_{adit.}$

- Нэг их холгүй газар тул, төөрдөг байшин шиг нарийхан олон сүлжилдсэн гудамжаар ороод эргэн тойрныг харан алхаллаа. (www.dailynews.mn); Тэрээр хүнтэй таарч болох бүхий л газраар яаран алхаж байжээ. (www.dailynews.mn) зэрэг өгүүлбэрт... машины цонхоор хараад л одоо тэнд явна гээд шууд хэлнэ. (www.dailynews.mn) “гудамжаар ороод”, “бүхий л газраар яаран алх-”, “машины цонхоор хараад” гэхийг “гудамж руу ороод”, “бүхий л газар руу яаран алх-”, “машины цонх руу хараад” гэж ойролцоо утгатай нөхцөлөөр солин найруулахдаа задлаг аргаар илрүүлдэг.

Г. 1. $N_{adit.}$

- Тэр нэлээд хэд хоногийн өмнө хот руу явсан. (www.dailynews.mn); Хөх даваанаас уруудаад Хар зааг, Хөндлөн булгаар дайраад Хөх хавцал руу овооны дэргэдээс өнгийхөд байгалийн олдошгүй гайхамшигт нэгэн зураг сэтгэлийг баясгаж зүрхийг догдлуулдаг бөлгөө. (www.dailynews.mn) гэхэд чиглэхийн тийн ялгал нь үндсэн үүргээрээ тохиолдоно.

2. $N_{adit.} \sim N_{dat.-loc.}$

- Манайх руу хийх айлчлалаа цуцлан байж нутгаадаа зорьсон гэнэ. (www.dailynews.mn); Залуучууд хот руу сургуульд явчхаад эргэж ирэн хотынхоо хөгжилд өөрсдийн хувь нэмрээ оруулдаг бодит хэрэгцээ шаардлага бий. (www.dailynews.mn); Өмнөд туйл руу арван хоёрдугаар сарын сүүл, нэгдүгээр сарын эхээр очих бололцоотой. (www.dailynews.mn) гэхэд “манайд хийх айлчлал”, “манай улсад хийх айлчлал”; “хот руу сургуульд явчхаад”, “хотод сургуульд явчхаад”, “хотын сургуульд явчхаад ...”, “өмнөд туйлд” гэх мэтээр тийн ялгалын нөхцөлийг солин найруулдаг.

3. $N_{adit.} \sim N_{accu.}$

- Би ганц нэг шүлгийн бадаг мөр унштал Сосор гуай уярч нүдэндээ нулимс мэлмэрүүлэн, Богд уул руу харж уртаар санаа алдсанаа “Цэнхэрлэн харагдана”-ыг хачин гоё дуулж билээ. (www.dailynews.mn); Мөн түүнчлэн 32 дахин томруулах чадал бүхий телескоп дуранг өөрөө зохион бүтээж, саран дээрх уул толгод руу ажиглаж байснаас гадна Улаан нүдэн гаргийн дөрвөн дагуул, нарны толбо зэргийг нээн тогтоосон байна. (www.dailynews.mn) гэхэд “Богд уул руу харах” гэхийг “Богд уулаад хар-”, “уул толгод руу ажигла-” гэхийг “уул толгодыг ажигла-” хэмээн тухайн үйлийн зорих, чиглэх утгыг заасан чиглэхийн тийн ялгалыг заахын тийн ялгалаар солин найруулахдаа задлаг аргыг нийлэг аргаар ч солих боломжтой байна.

Иймд монгол хэлний үйлдэх, өгөх орших, гарахын тийн ялгал нь орон цагийн утга илтгэх төдийгүй цөм шалтгаан байдал, хамтрахын утга заадгаараа ижил юм. Харин гарахын тийн ялгал нь харьцуулах утгыг тодорхой илтгэдгээрээ бусдаас ихээхэн ялгаатай юм (Базаррагчаа, 1991) гэсэн бол монгол хэлний харьяалах харьцааны утга зүйн асуудал (Бадамдорж, 1982) болон харьяалахын тийн ялгал нь ихээхэн хийсвэрлэсэн харьцааг заах тул бусад тийн ялгалын утгыг агуулж байдаг (Базаррагчаа, М) хэмээн тусгайлан судалсан тул энд харьяалахын тийн ялгалыг задлаг хам бүтцээр хэрхэн илрүүлэх талаар дурдаагүй болно.

Монгол хэлний гарах ба үйлдэхийн тийн ялгал, өгөх орших ба чиглэхийн тийн ялгалыг хослуулан ухаарч болохын зэрэгцээ үйлдэх, гарах, чиглэхийн тийн ялгалаар хэлбэржсэн үг нь үйл хөдөлгөөн заасан үйл үгэнд захирагдаж, өгөх оршихын тийн ялгалын үйлийн орших орон,

байрыг заах хэл зүйн харьцааг зааж байгаа тул монгол хэлний орон заасан тийн ялгалын утгыг задлаг аргаар илрүүлэхэд орон цагийн нэр чухал үүрэгтэй хэмээн үзсэн болно. Энэ нь энэтхэг европын хэлэнд ихэвчлэн угтвар үгээр илэрдэг бол монгол хэлний практик найруулга зүйн жишээнээс ажиглахад задлаг аргаар илэрвэл тийн ялгал нь хэлбэрийн хувьд ялгаатай ч, утгын хувьд солин найруулах боломжтой гэсэн үг юм.

Монгол хэлний найруулга зүйд үгийн санд нэг үгээр олон утга илтгэж, олон үгээр нэг утга илрүүлж болдог тул найруулга зүйн зөв сонголт хийх боломжтой юм. Үүнчлэн олон ойролцоо дагавар, нөхцөл, холбоо үг, өгүүлбэрээр нэг утга санаа гаргах буюу нэг дагавар нөхцөл, нэг холбоо үг, нэг өгүүлбэрээр олон утга санаа илрүүлэх боломж бий. Нэг үгийн дараа буюу ямар ч үг хамаагүй залган байрлаж болохгүйн адил нэг дагавар, холбоо үг, өгүүлбэрийн дараа бусад дагавар, холбоо үг, өгүүлбэр хамаагүй залгаж байрлаж болохгүй, эх хэлний хууль зүйн дагуу хэвшсэн нягт байрлалтай байна. Энэ бол найруулгын эрхэм дэг юм (Сүхбаатар, 2015) гэжээ. Иймд практик найруулга зүйн талаас дээрх агуулгыг дараах жишээгээр тодруулбал,

- а. Хүмүүс уул-н-д (dat-loc.) алхав. (Хүмүүс уулаад өгсөөд буусан.)
Хүмүүс уул руу алхав.
- б. Хүмүүс уул-н-аас (abl.) буув. (Хүмүүс ууланд байгаад нааш ирж байна.)
Хүмүүс уулан дээрээс буув.
- в. Хүмүүс уул-аар (inst.) алхав. (Хүмүүс уулыг эгц биш хөндлөн ороож ийш тийш хэрэн алхав.)
Хүмүүс уулан дээгүүр нэлээд алхжээ.
- г. Хүмүүс уулаад (dir.) алхав. (Хүмүүс ууланд хүрээгүй чиглээд явж байна)
Хүмүүс уул өөд/уул руу алхав.

Монгол хэлний S-OBL-V_{intrans.} бүтэцтэй өгүүлбэрт үйл үгэнд захирагдаж байгаа шууд бус тусагдахууны нөхцөлийн утга нь үйл үгийн утгаас шалтгаална. Жишээлбэл, “алхах” гэсэн үйл үг нь “урагшлах, алгасах, давах” гэсэн хөдөлгөөний утгатай бөгөөд шатаар алхах (а.өгсөх б.дээшлэх), босгоор алхах (а.үүдээр алхаж орох, б.шалгуур давах) гэхэд орон зайн утга, өглөөгүүр алхах, үдээр алхах, эхэнд алхах (тэргүүнд алхах) гэхэд цагийн утгаар (VP) үйл үгэнд захирагдсан нөхцөл нь тийн ялгалын үүргээр орсон бол харин шилжсэн утгаар босго-оор/-ыг алхахгүй (хэзээ ч орохгүй гэсэн утгатай), сар алхах (төрөх хугацаа өнгөрөх), жасаа алхах (ээлж өнгөрөөх) гэхэд нөхцөл нь утгын хувьд харьцаа зааж холбох үүрэгтэй болно. Иймд цаашид монгол хэлний үйлийн холбоо үгийг хэл зүйн талаас судлахаас гадна үйл үгийн утгын хамаарлыг танихуйн хэл зүйн талаас судлах хэрэгцээ урган гарч байна.

Монгол хэлний холбоо үг нь хүмүүсийн саналаа солилцох харьцангуй утга төгс дохио-өгүүлбэр болж чадахгүй боловч түүнгүйгээр тухайн хэлний ямар ч дэлгэрэнгүй өгүүлбэр байж чадахгүй юм. Холбоо үг бол өгүүлбэр бүтээх гол материал болно (Рагчаа, 1975) гэжээ. Энэ нь цаашид монгол хэлний сургалтад нийлэг ба задлаг аргаар илрэх үйлийн холбоо үгийг утга зүйн танин мэдэхүйн талаас судлах нь хэл шинжлэл хийгээд монгол хэл заах арга зүйн хувьд онол, практикийн салшгүй холбоотой асуудал болох нь тодорхой байна. Мөн орны байц гишүүн өгүүлбэрт “-сан⁴+ы² дээр, -сан⁴+ы² дотор, -сан⁴+ы² хажууд, -сан⁴+ы² хажуугаар, -сан⁴+ы² дэргэд, -сан⁴+ы² дэргэдүүр, -сан⁴+ы² наагуур, -сан⁴+ы² цаагуур, -сан⁴+ы² урдуур, -сан⁴+ы² хойгуур, -сан⁴+ы² араар; -сан-ы хойно, -сан-ы дээш, -сан-ы доош, -сан-ы дээгүүр, -сан-ы доогуур, -сан-ы хооронд” гэх хэлбэрээр харин цагийн байц гишүүн өгүүлбэрт “-сан⁴ хойно, -сан⁴ хойгуур; -сан⁴+ы² хойно, -сан⁴+ы² дараа, -сан⁴+ы² хойгуур; -сан⁴+аас⁴ хойш, -сан⁴+аас⁴ цааш (өнгөрсөн цаг); -х үед, -х үес, -х зуур, -х хооронд, -х завсар, -х турш; -х+ын үед, -х+ын алдад (одоо цаг); -х хүртэл, -х+ын² өмнө (өмнөхөн), -х+ын² урьд; -х+аас⁴ өмнө, -х+аас⁴ нь өмнө (ирээдүй цаг) зэрэг хэлбэрээр илэрдэг тул цаашид албан бичиг, эрдэм шинжилгээ, сонин нийтлэл, уран зохиол, ярианы найруулгын төрөлд ямар давтамжтай, хэрхэн ашиглагдаж буйг хэрэглээгээр нь эрэмбэлэх боломжтой юм.

Үүнээс үзвэл, орчин цагийн монгол хэлний өгүүлбэрт орны утгат тийн ялгал нийлэг аргаар илрэхийн зэрэгцээ харьяалах, гарахын тийн ялгалаар хэлбэржсэн нэр үгийг захирдаг

монгол хэлний хувилах ба үл хувилах үгсийн хоёрдмол шинжийг хадгалсан орон цагийн нэр өгүүлбэрт задлаг аргаар илрэхдээ хэлзүйжсэн холбоо үгийн үүргээр орж үйл үгэнд захирагдан орон цагийн байц гишүүн болно. Мөн орчин цагийн монгол хэлэнд орон байр, зүг чигийн утгатай орон заасан өгөх орших, гарах, үйлдэх, чиглэхийн тийн ялгалууд нь хоорондоо хэл зүйн харьцаатай төдийгүй зарим тохиолдолд бүтээвэр ба өгүүлбэрийн завсрын утга нь ойролцоо байвал солин найруулах боломжтой төдийгүй задлаг аргаар ч илэрч болно.

Abstract

In Mongolian language has eight types of case suffixes, which are nominative, genitive, dative-locative, accusative, ablative, instrumental, comitative and directive case. In Mongolian language the case includes spatial case. Dative-locative, ablative, instrumental, directive case are of spatial cases in Mongolian, which has semantic correlation. Within the structural cases, dative-locative, ablative, instrumental, directive case can change to each other, but the reverse alternation is ruled. The relevant observation is that, synthetic structure with “spatial case” and the analytical method with “дээр, дотор, хооронд” and used in VP and SOV. The analytical method commonly used to grammatical word.

Ном зүй

- Алексеев Д. 1941. *Наречие бурят-монгольском языке*. Улан-Үдэ.
- Алексеев А. 1962а. *Наречие. Грамматика бурятского языка, фонетика и морфология*. Москва.
- Алексеев Д. 1962b. *Послелогии. Грамматика бурятского языка. Фонетика и морфология*. Москва.
- Амоголонов Д. 1958. *Современный бурятский язык*. Улан-Үдэ.
- Базаррагчаа М. 2005. *Монгол хэлний өгүүлбэр судлал*. Улаанбаатар.
- Базаррагчаа М. 1991. *Монгол хэлний тийн ялгалын утгыг ангилах нь*. Монгол судлалын бичиг, I. 7-19.
- Базаррагчаа М. 1992. *Харьяалахын тийн ялгалын утгыг ангилах нь*. Монгол судлалын бичиг, XIII (139). 56-90.
- Барайшир Ш. 1958a. *Монгол хэлний дайвар үг*. Улаанбаатар.
- Барайшир Ш. 1958b. *Орчин цагийн монгол хэлний дагавар үгийн тухай*. Улаанбаатар.
- Барайшир Ш. 1966. *Дагавар үг, Орчин цагийн монгол хэл зүй*. Улаанбаатар.
- Барайшир Ш. 1974. *Орчин цагийн монгол хэлний дайвар үг*. Улаанбаатар.
- Бадамдорж Д. 1982. *Монгол хэлний харьяалах харьцааны утга зүйн асуудалд*. Хэл зохиол судлал, XVII. 94-102.
- Бертагаев Т.А., Цыдендамбаев Ц. 1962. *Грамматика бурятского языка, Синтаксис*.
- Бертагаев Т. 1964. *Синтаксис современного монгольского языка в сравнительном освещении. Простое предложение*. Москва.
- Бертагаев Т. 1969. *Морфологическая структура слова в монгольских языках*. Москва.
- Бобровников А. 1835. *Грамматика монгольского языка*. Санктпетербург.
- Бобровников А. 1849. *Грамматика монгольско-калмыцкого языка*. Казань.
- Buck F.H. 1955. *Comparative study of postpositions in Mongolian dialects and the written language*. Harvard-Yenching Institute Studies XII.: Harvard University Press, Cambridge, Massachusetts.
- Доржиев Д. 2002. *Мүнөөнэй буряад хэлэн. Морфетикэ*. Улан-Удэ.
- John C. S. 1963. *Khalkha Structure*. Bloomington: Indiana University.
- Котвич В. 1902. *Лекций по грамматике монгольского языка*. Санктпетербург.
- Котвич В. 1929. *Опыт грамматики калмыцкого разговорного языка, II*. Прага.
- Ковалевский О. 1835. *Краткая грамматика монгольского книжного языка*. Казань.
- Лидженева Л. 2004. *Послелогии калмыцкого языка в историко-сопоставительном освещении в тема автореферата, Элиста*.
- Лувсанвандан Ш. 1961. *Орчин цагийн монгол хэл*. Бээжин.
- Лувсанвандан Ш. 1955. *Монгол хэлний дайвар үгийн учир*. Багш сэтгүүл, 1.
- Лувсанвандан Ш. 1956. *Монгол хэлний зүй*. Улаанбаатар.
- Лувсанвандан Ш. 1965. *Орчин цагийн монгол хэлний шууд ба шууд бус тийн ялгалын тухай*. МУИС, ЭШБ, VIII (2(16)). х. 25-30.
- Лувсанвандан Ш. 1968. *Орчин цагийн монгол хэлний бүтэц, Монгол хэлний үг нөхцөл хоёр нь*. Улаанбаатар.
- Мишиг Л. 1957a. *Дагавар үг бүхий холбоо үгийн зүйл, Монгол хэлний холбоо үгийн зүйл*. Улаанбаатар.
- Мишиг Л. 1957b. *Монгол хэлний тусагдахуун ба байц*. Улаанбаатар.
- Орловская М. 1961. *Имена существительные в современном монгольском языке*. Москва.

- Орлов А.** 1878. *Грамматика монголо-бурятского разговорного языка*. Казань.
- Орчин цагийн монгол хэлний зүй.** 1966. ШУА. Улаанбаатар.
- Өнөрбаян Ц.** 2004. *Орчин цагийн монгол хэлний үг зүй*. Улаанбаатар.
- Поппе Н.** 1937. *Грамматика письменно-монгольского языка*. Москва., Ленинград.
- Поппе Н.** 1938. *Грамматика бурят-монгольского языка*. Москва., Ленинград.
- Попов А.** 1879. *Грамматика калмыцкого языка*. Казань.
- Пюрбеев Г.** 1993. *Историко-сопоставительные исследования по грамматике монгольских языков, Синтаксис словосочетания*.
- Rorpe N.** 1951. *Khalkha-Mongolische Grammatik*. Wiesbaden.
- Rorpe N.** 1954. *Grammar of written Mongolian*. Wiesbaden.
- Rorpe N.** 1955. *Introduction to Mongolian Comparative Studies*. Helsinki.
- Rorpe N.** 1960. *Buriat Grammar*. Bloomington.
- Чойжинжав.** 1987. Монгол хэлний үгсийн аймгийн тухай дахин өгүүлэх нь. Монгол хэл шинжлэлийн өгүүллүүд, х. 595.
- Руднев А.** 1905. *Лекций по грамматике монгольского письменного языка*. Санктпетербург.
- Санжеев Г. Д.** 1940. *Грамматика калмыцкого языка*. Москва., Ленинград.
- Санжеев Г. Д.** 1941. *Грамматика бурят-монгольского языка*. Москва.
- Санжеев Г. Д.** 1953. *Сравнительная грамматика монгольских языков. Глагол*. Москва.
- Санжеев Г. Д.** 1960. *Современный монгольский язык*. Москва.
- Санжеев Г.Д.** (Ed.). 1962. *Грамматика бурятского языка. Фонетика и морфология*.
- Сүхбаатар Ц.** 2015. *Монгол хэлний найруулга зүй*. Улаанбаатар.
- Тодаева Б.** 1951. *Грамматика современного монгольского языка. Фонетика и морфология*. Москва.
- Төмөртоого Д.** 1992. *Монгол хэлний түүхэн хэл зүйн үндэс*. Улаанбаатар.
- Трофимова С.** 1989. *Падежно-последовательные конструкции монгольских языков и их русские экваленты*. Элиста.
- Өнөрбаян Ц.** 2004. *Орчин цагийн монгол хэлний үг зүй*. Улаанбаатар.
- Рагчаа Б.** 1975. *Орчин цагийн монгол хэлний бодит нэрийн холбоо үг*. Улаанбаатар.
- Ринчен Б.** 1967. *Монгол бичгийн хэлний зүй*. Улаанбаатар.
- Hambis L.** 1945. *Grammaire de la Langue Mongole Ecrite*. Paris.
- Цыдыпов Ц.** 1972. *Аналитические конструкции в бурятском языке*. Улан-Удэ.
- Цыдыпов Ц.** 1985. *Буряд хэлэнэй синтаксис*. Улан-Удэ.
- Цыдыпов Ц.** 1988. *Морфология бурятского языка. (Буряд хэлэнэй морфологи)*. Улан-Удэ.
- Цэцэнцогт.** 1988. *Монгол үгсийн язгуурын толь*. ӨМАХХ.
- Чареков С.** 1989. Наречие в монгольских языках в сравнений с другими алтайскими языками. In *Грамматическое исследование по отдельным алтайским языкам* (p. 93). Ленинград.
- Chingeltei.** 1963. *A Grammar of the Mongol Language*. New York.
- Schmidt I.** 1831. *Grammatik der Mongolischen Sprache*. St.Petersburg.
- Энхтуяа Н.** 1993. *Сочетаемость потенции адverbальных слов в монгольском и русском языках*, Дисс. канд. Улаанбаатар.

Ашигласан хэрэглэгдэхүүн:

www.dailynews.mn